



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/006/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг  
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerguibaatard@audit.gov.mn](mailto:Nerguibaatard@audit.gov.mn)

Аудитор Л.Соёлмөнх  
Утас: 7033-3019

Цахим хаяг: [Soyolmunkhl@audit.gov.mn](mailto:Soyolmunkhl@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.24 № 157  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
С.АДЪЯАСҮРЭН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Сумын 2024 оны төсвийн 5 нэр төрлийн орлогыг төлөвлөснөөс нийт 70,938.5 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;
2. Хоршоо хөгжүүлэх сангийн 6 зээлдэгчтэй холбоотой 65,372.9 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;
3. Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 108,156.1 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй;

Дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, 44 дүгээр зүйлийн 44.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1, 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.23.1, 3.9.7, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11, 10 дугаар зүйлийн 10.1, 11 зүйлийн 11.3 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна. Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 3,243,861.3 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 2,828,697.4 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 415,163.9 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 104 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88 арга хэмжээг 100 хувь, 4 арга хэмжээг 90 хувь, 3 арга хэмжээг 70 хувь, 6 арга хэмжээг 50-аас доош хувийн гүйцэтгэлтэй биелүүлж, 3 арга хэмжээ огт хэрэгжээгүй бөгөөд тайлант онд дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс **60.6** хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,837,310.65</b>	<b>1,410,752.09</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,439,395.93	970,596.01
33	АВЛАГА	312,069.11	351,820.40
35	БАРАА МАТЕРИАЛ	85,845.62	88,335.68
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,593,898.45</b>	<b>2,965,248.93</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,593,898.45</b>	<b>2,965,248.93</b>
39200	Биет хөрөнгө	1,575,806.45	2,925,361.93
39300	Биет бус хөрөнгө	18,092.00	39,887.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,431,209.11</b>	<b>4,376,001.02</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,431,209.11</b>	<b>4,376,001.02</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,431,209.11</b>	<b>4,376,001.02</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	527,026.42	527,026.42
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,671,972.28</b>	<b>3,616,764.19</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	232,210.40	232,210.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,431,209.11</b>	<b>4,376,001.02</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,951,288.17</b>	<b>3,674,263.20</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>746,209.25</b>	<b>988,152.75</b>
110	Орлогын албан татвар	294,226.70	644,992.99
1100	Хувь хүний орлогын албан татвар	294,100.70	644,822.99
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	126.00	170.00
113	Хөрөнгийн албан татвар	131,568.15	77,954.74
118	Бусад татвар, төлбөр, хураамж	320,414.39	265,205.02
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>358,182.44</b>	<b>1,641,924.82</b>
120	Нийтлэг татварын бус орлого	358,182.44	1,641,924.82
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>846,896.48</b>	<b>1,044,185.63</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,332,625.79</b>	<b>2,146,685.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,332,625.79</b>	<b>2,146,685.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,317,454.39</b>	<b>2,069,911.91</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	499,194.39	784,913.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,541.98	95,573.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,311.65	208,934.37
2104	Хангамж, бараа материалын зардал	75,999.34	66,910.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,515.60	76,628.57
2107	Томилт, зочны зардал	6,900.30	10,641.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,046.68	14,318.45
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	506,944.45	811,991.33
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,171.40</b>	<b>76,773.90</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>618,662.38</b>	<b>1,527,577.40</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>442,285.00</b>	<b>608,823.23</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>176,377.38</b>	<b>918,754.17</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,024,560.29</b>	<b>2,394,797.48</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>746,209.25</b>	<b>988,152.75</b>
110	Орлогын албан татвар	294,226.70	644,992.99
1100	Хувь хүний орлогын албан татвар	294,100.70	644,822.99
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	126.00	170.00
113	Хөрөнгийн албан татвар	131,568.15	77,954.74
118	Бусад татвар, төлбөр, хураамж	320,414.39	265,205.02
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,626.87	16,785.50
1181	Газрын төлбөр	10,758.70	83.07
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	286,028.82	248,336.44
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>431,454.57</b>	<b>362,459.10</b>
120	Нийтлэг татварын бус орлого	431,454.57	362,459.10
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>846,896.48</b>	<b>1,044,185.63</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,037,172.27</b>	<b>1,877,352.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,037,172.27</b>	<b>1,877,352.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,022,000.87</b>	<b>1,800,578.67</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	500,983.29	784,913.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,753.08	95,573.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,040.00	208,934.37
2104	Хангамж, бараа материалын зардал	54,035.15	65,124.33
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,365.60	46,504.35
2107	Томиллот, зочны зардал	6,900.30	10,641.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,752.85	49,218.45
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	229,170.60	539,668.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,171.40</b>	<b>76,773.90</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>987,388.02</b>	<b>517,444.91</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>478,085.00</b>	<b>886,244.83</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>478,085.00</b>	<b>886,244.83</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	478,085.00	886,244.83
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(478,085.00)</b>	<b>(866,244.83)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(110,349.85)</b>	<b>(100,000.00)</b>
	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>110,349.85</b>	<b>100,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>398,953.18</b>	<b>(468,799.92)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,040,442.75	1,439,395.93
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,439,395.93	970,596.01

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,254,831.72</b>	<b>3,254,831.72</b>
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,254,831.72	3,254,831.72
9	Тайлант үеийн үр дүн	176,377.38	176,377.38
<b>10</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,431,209.11</b>	<b>3,431,209.11</b>
<b>11</b>	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>3,431,209.11</b>	<b>3,431,209.11</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	26,037.74	26,037.74
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,457,246.85	3,457,246.85

19	Тайлант үеийн үр дүн	918,754.17	918,754.17
<b>20</b>	<b>2024 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл</b>	<b>4,376,001.02</b>	<b>4,376,001.02</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,243,861.30</b>	<b>2,828,697.40</b>	<b>415,163.90</b>	<b>87.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,171,082.30</b>	<b>1,978,696.07</b>	<b>192,386.23</b>	<b>91.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,094,308.40</b>	<b>1,901,922.17</b>	<b>192,386.23</b>	<b>90.81</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	852,401.60	784,913.89	67,487.71	92.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,469.20	95,573.37	18,895.83	83.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,073.80	208,934.37	8,139.43	96.25
2104	Хангамж, бараа материалын зардал	66,685.60	65,124.33	1,561.27	97.66
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,300.00	73,559.35	6,740.65	91.61
2107	Томилолт, зочны зардал	12,134.20	10,641.00	1,493.20	87.69
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,717.80	14,318.45	12,399.35	53.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	724,526.20	648,857.41	75,668.79	89.56
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,773.90</b>	<b>76,773.90</b>	-	<b>100.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,773.90	76,773.90	-	100.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>828,172.30</b>	<b>750,001.33</b>	<b>78,170.97</b>	<b>90.56</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>244,606.70</b>	<b>100,000.00</b>	<b>144,606.70</b>	<b>40.88</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,243,861.30</b>	<b>2,575,432.35</b>	<b>668,428.95</b>	<b>79.39</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,648,392.00</b>	<b>2,474,743.00</b>	<b>(826,351.00)</b>	<b>150.13</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,595,469.30</b>	<b>100,689.35</b>	<b>1,494,779.95</b>	<b>6.31</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	403,985.16	(403,985.16)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	150,720.11	(150,720.11)	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	-	<b>100.00</b>
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28	27	1.00	96.43
62	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	27	1.00	96.43

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>62,133.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>62,133.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>24,900.00</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний бусад төлбөр хураамжийн зардал	34,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,233.13</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,233.13
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>62,133.13</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,133.13

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй тул санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Залруулаагүй нийт **244,467.5** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч ОНХС-тай холбоотой 108,156.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 136,311.4 мянган төгрөгийн ХХС-ийн авлага болон орлоготой холбоотой зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 244,467.5 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **36,493.4** мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сумын төвд гэрэлтүүлэг тавих 68,956,100 төгрөгийн, сумын төвөөс орох гарах 3 газарт болон гудамж хорооллыг камержуулах 19,700,000 төгрөгийн, Эрдэнэ-Уул багийн “Өндөр эрэг”-ийн амнаас Мухар элэгдийн голын гүүр хүртэлх замын 19,500,000 төгрөгийн нийт 108,156,100 төгрөгийн 3 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11.1 “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоож, ОНХС-ийн бий болсон дээрх хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэл тайланд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах шаардлага хүргүүлээ.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 5.3.1. Орлоготой холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Сумын 2024 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн боловч малын тоо толгойн албан татвар 69,219,900 төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 116,000 төгрөгөөр, галт зэвсгийн албан татвар 180,000 төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 168,600 төгрөгөөр, хүү торгуулийн орлого 1,254,000 төгрөгөөр, нийт 5 нэр төрлийн орлого 70,938,500 төгрөгөөр тасарсан, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна

**Өгсөн зөвлөмж:** Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах

#### 5.3.2. Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Илрүүлэлт:** Сумын хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 6 зээлдэгчтэй холбоотой 65,372,090 төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Хоршоо хөгжүүлэх сангийн 65,372,900 төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар холбогдох хууль, тогтоомжид заасан арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн санг хохиролгүй болгох

### **5.3.3. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийн дийлэнх хувийг цалингийн сангаас зориулалт бус зарцуулсан зөрчил эзэлж байна. Түүнчлэн сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 18,500,000 төгрөгийн урсгал үйл ажиллагаанаас санхүүжих эрх олгосон зөрчил нь сумын санхүүгийн алба, төрийн сангаас төсөвт байгууллагуудын төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналт сул байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.23.1-т “Төсвийн тухай хуулийн ... 44.3-т заасан болон холбогдох хууль тогтоомжид төсвөөс зарлага гаргахыг хориглосон”, 3.9.7-д “Энэ журмын 3.9.3.3-т заасан дотоод хяналтыг бүх шатны төрийн сан үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.7-д заасан өдөр тутмын хяналтыг тогтмол хэрэгжүүлж, үр дүнг сайжруулах арга хэмжээг авах

*Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлоготой холбоотой	1	70,938.5	-	-	-	-	1	70,938.5	-	-	-	-
ХХС-тай холбоотой	1	65,372.9	-	-	-	-	1	65,372.9	-	-	-	-
ОНХС-тай холбоотой	1	108,156.1			1	108,156.1	-	-				
Дотоод хяналттай холбоотой	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4</b>	<b>244,467.5</b>	-	-	<b>1</b>	<b>108,156.1</b>	<b>3</b>	<b>136,311.4</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн данс	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-